



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/167

Бор-Өндөр сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 70.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримт бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэний эзэмших эрхийн гэрчилгээг Нэгдүгээр хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2019 оны А/199 тоот захирамжийн Г.Ганхуяг, 2024 оны А/108 тоот захирамжийн Б.Билэгням нарт холбогдох хэсгүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ

Сумын Засаг даргын 2025 оны ..07

дугаар сарын ..02-ны өдрийн
А/167-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчдийн мэдээлэл

д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ²	Эзэмших хугацаа	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Эрх шилжүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Боржигин Лувсанпүрэв Саранзаяа	ЕТ84062803	50	7	1-р баг Бор-Өндөр, Худалдаа-1 гудамж, 115 тоот	2322002398	Худалдаа үйлчилгээ	Хошууд Баатарчулуун Билэгням СЦ88073009	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.06.25 №0349
2			7500	7	2-р баг Холбоо, Шинэ зам-1 гудамж, 103 тоот	2322002483	Шатахуун түгээх станц	Хуучид Гомбосүрэн Ганхуяг СЦ72080711	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.06.24 №0339